



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 06 сарын 17 өдөр

Дугаар 87/БС

Улаанбаатар хот

Ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.7 дахь заалт, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны А/09 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр "ЖАНЫ ОВОО" ХХК-ны гүйцэтгэсэн "2 дугаар хорооны Соёлын төвийн засварын ажил"-г ашиглалтад хүлээн авах Ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн

ахлагч:

Д.Хүрэлбаатар

Тохижилт, худалдаа үйлчилгээний хэлтсийн дарга

Гишүүд:

Н.Өлзийцэцэг

Архивын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

Б.Батзориг

2 дугаар хорооны Засаг дарга

М.Даваадорж

УБТЗ-ын барилга, засвар ашиглалт үйлчилгээний ангийн Багахангай хэсгийн мастер

Нарийн бичиг:

О.Нэргүй

"Жаны овоо" ХХК-ны захирал

2.Ашиглалтад хүлээн авах ажлыг холбогдох хууль, журмын дагуу чанар гүйцэтгэлд хяналт тавин хүлээн авах ажлыг зохион байгуулж, эргэн танилцуулахыг Ажлын хэсэг (Д.Хүрэлбаатар)-т үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, ажиллахыг Засаг даргын орлогч (Х.Цогцэцэг)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД